



Арилжааны мэдээ

- Монголын хөрөнгийн бирж 2020 оны 9 дүгээр сарын 7-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, нийт 380,648,281.55 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,586,973,782,874.55 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 16,898.25 нэгж болж өмнөх долоо хоногоос 0.03 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

MSE Top 20 индекс


Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа


Эх сурвалж: Монгол Банк

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	16,898.25	-0.03 %
MSE A индекс	8,243.92	0.05 %
MSE B индекс	7,353.14	-0.14 %

Зах зээлийн хураангуй
Нийт (MNT)

Зах зээлийн үнэлгээ	2,586,973,782,874.55
Арилжигдсан үнийн дүн	380,648,281.70

Үнийн дүнгээр
Хаалт (MNT)
Нийт

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	1,050.00	199,404,375.00
МАНДАЛ ДААТГАЛ ХК	41.74	38,097,035.47
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	850.05	30,092,038.85
ЛЭНДМН ББСХ ХК	30.99	20,386,427.58
АПУ ХК	580.20	16,458,500.93

Тоо ширхэгээр
Хаалт (MNT)
Нийт

МАНДАЛ ДААТГАЛ ХК	41.74	886,437
ЛЭНДМН ББСХ ХК	30.99	676,784
МОНОС ХУНС ХК	65.00	206,963
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	1,050.00	189,955
ДАРХАН НЭХИЙ ХК	14.79	62,667

Ханш өссөн
Хаалт (MNT)
% Өөрчлөлт

МАТЕРИАЛИМПЕКС ХК	8,265.00	17.98 %
МАХИМПЕКС ХК	2,999.00	17.51 %
ТЕХНИК ИМПОРТ ХК	8,055.00	14.98 %
МОНГОЛ САВХИ ХК	550.00	13.90 %
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ ХК	99.00	10.00 %

Ханш буурсан
Хаалт (MNT)
% Өөрчлөлт

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	130.00	-15.58 %
ХИШИГ УУЛ ХК	580.00	-14.95 %
БЭРХ УУЛ ХК	440.00	-13.72 %
ТАЛХ ЧИХЭР ХК	13,000.00	-13.27 %
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	1,259.00	-13.11 %

Тодруулга

Ханшийн өөрчлөлтийн мэдээг 9 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаарх ханштай харьцуулав.

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ**ЭРДЭНЭ РЕСУРС НЬ БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТЭЗҮ-ИЙН ЭЭРЭГ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАВ. (mse.mn)**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-г National Instrument 43-101 тайлагналын стандартын дагуу боловсруулж, Канад улсын цахим тайлангийн SEDAR системд бүртгүүлсэн байна.

Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу.

Нарийвчилсан ТЭЗҮ-ийн тайланг [эндээс](#) үзнэ үү.

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН 2019 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА. (schcd.mn)

“Монос хүнс” ХК-ийн 2019 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 0 төгрөг 90 мөнгө тараасныг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Д.БАЯРСАЙХАН: КОМПАНИЙН НЭЭЛТТЭЙ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ ХЯЛБАР, ШУУРХАЙ БОЛГОНО. (frc.mn)

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Bloomberg” телевизийн “Зочны цаг”-д оролцож цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариулт өглөө. Тэрбээр ярилцлагын үеэр компанийн бондын зах зээлийг хөгжүүлснээр зах зээл дээр хөрөнгө оруулах бүтээгдэхүүний тоо, төрөл нэмэгдэх, хөрвөх чадвар дээшлэх эерэг талууд бий болно. Иймээс Хороо бондын биржийн болон биржийн бус зах зээлийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Энэ ч утгаараа энэ удаагийн зээлийн хүүг бууруулах стратегийн төсөлд бондын зах зээлийг хөгжүүлэх ажлыг тусгайлан оруулж өгсөн гэдгийг онцолсон юм.

АХБ, ДЭЛХИЙН БАНК ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТойГООР МОНГОЛ УЛСАД ОЛГОХ 220 САЯ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ БАТЛААД БАЙНА. (bloombergtv.mn)

Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг давахад зориулж Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас Монгол Улсад 220 гаруй сая ам.долларын санхүүжилт батлаад байна.

Тухайлбал: Азийн хөгжлийн банк шуурхай арга хэмжээний хөтөлбөрөөр 100 сая ам.долларын зээл, тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төслийн хүрээнд 26.4 сая ам.долларын зээл баталсан юм.

Харин Дэлхийн банк хөдөлмөр эрхлэгчдийн санхүүгийн ачааллыг багасгах төслийн 20 сая ам.долларын зээл, цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээнд зориулсан 27 сая ам.долларын зээл олгохоор батлаад байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын гадаад өр 7.9 тэрбум ам.доллар хүрээд байгаа юм. Өөрөөр хэлбэл эхний улирлаас хойш 655 сая ам.доллараар өссөн байна. “Fitch” агентлаг энэ долоо хоногт танилцуулсан шинэ тайландаа Ази, Номхон далайн дийлэнх улсын Засгийн газрын өр нэмэгдэж байгаа нь бодлогын гол сорилт болно гэж дүгнэсэн юм. Мөн дунд болон урт хугацаанд төсвийн орлого нэмэгдэж, зардлаа аажмаар бууруулах боломж бүрдэнэ. Хэдий тийм боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх Засгийн газрын өр ойрын хугацаанд үргэлжлэн өсөхөөр байна гэжээ.

ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ “ИНВЕСКОР ББСБ” ХК 18.27 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН 596 ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖЭЭ. (bloombergtv.mn)

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй Банк бус санхүүгийн байгууллагууд оны эхний хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа танилцууллаа.

Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт орлого тайлант хугацаанд 9.8 тэрбум төгрөг байсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Тус компани 2.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэл учирч зээлдэгчийн орлого багасах болон тасалдах байдал үүсэж байгаатай холбоотойгоор харилцагч тухайн зээлээ нэгээс олон удаа сунгах боломжийг олгож эхэлсэн гэж компани онцолсон байна. Үр дүнд нь II улиралд зээл сунгалт 166 хувиар өсөж, 63.7 тэрбум төгрөг болсон байна.

“Топ-20” индексийн сагсанд шинээр багтсан “Инвескор ББСБ” ХК-ийн хувьд оны эхний хагаст 13.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 61 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Цэвэр ашиг нь мөн 52 хувиар өсөж, 6.1 тэрбум төгрөг болсон байна. “COVID-19”-тай холбоотой бизнесийн үйл ажиллагаа нь хүндэрсэн харилцагч нарынхаа зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэн ажилласан байна. Улмаар 18.27 тэрбум төгрөгийн 596 зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулжээ. Үүнээс гадна тус компани Киргиз улсын Төв банканд цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргасан байна. “Инвескор ББСБ” ХК-ийн нэгж хувьцааны ханш нь зургаадугаар сарын 30-ны байдлаар өмнөх оны мөн үеэс 39.5 хувиар өсөж, 2514 төгрөг хүрснийг Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ.

Харин “Ард кредит ББСБ” ХК II улиралд нийт 548 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаа тайлагнажээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48 хувиар буурсан дүн болсон байна. Тус компани тайлант хугацаанд “Ард” апп-аар дамжуулан 300 мянган харилцагчдадаа 53 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Зээлийн бүтцийн 50 гаруй хувийг “Fastcash” бүрдүүлсэн бол 20 гаруй хувийг жижиг, дунд үйлдвэрлэл болон бизнесийн зээл бүрдүүлсэн байна.



“БиДиСЕК ҮЦК” ХК

Андеррайтер, Брокер
Хөрөнгө оруулалтын зөвлөх

Арилжааны мэдээ

38 дахь долоо хоног, 2020

О.Уранбайгаль

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919

Б.Онон

Харилцагчийн алба, ахлах мэргэжилтэн
И-мэйл: onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919

Д.Сарантуяа

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: darkhan@bdsec.mn

БиДиСек Дархан салбар

Дархан их дэлгүүр 603 тоот,
16-р баг, Дархан сум,
Дархан хот, Монгол улс
Утас: 976-7555-1919

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.